



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 338

Улаанбаатар хот

Компанийн эзэмшигчдийн өмч дэх
төрийн өмчийн дүн, дүрэмд өөрчлөлт
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, бусад хөрөнгийн эх үүсвэрээр 2016-2017 онд хийгдсэн нийт 15,596,367,727.00 /арван таван тэрбум таван зуун ерэн зургаан сая гурван зуун жаран долоон мянга долоон зуун хорин долоон/ төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийн дүнгээр “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.


2. “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 5.1 дэх заалтанд “Компани нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 69,567,184.00 /жаран есөн сая таван зуун жаран долоон мянга нэг зуун наян дөрөв/ ширхэг хувьцаатай” гэснийг “Компани нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 155,963,677.00 /нэг зуун тавин таван сая есөн зуун жаран гурван мянга зургаан зуун далан долоо/ ширхэг хувьцаатай” гэж өөрчилсүгэй.

3. “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг компанийн гүйцэтгэх захирал С.Жаргалсайханд үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлого, төлөвлөлт удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002087